



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-3-21 № 03/26

Зөрчил арилгуулах тухай

Сүхбаатар дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн 2012 оны санхүүгийн тайланд 23.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

2012 оны 12 дугаар сарын 10-аас 2013 оны 2 дугаар сарын 1-ийг хүртэл 50 хоногийн хугацаатай “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр тендер зарлаж, “ЭТ” хоршоонд 15,6 сая, “Сайн үйлс сэтгэлийн дуудлага” ТББ-д 7,6 сая, нийт 23,2 сая төгрөг олгосон боловч холбогдох анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн, зардлын гүйцэтгэл болон, гэрээ дүгнээгүй, ажлын хөлсийг 100 хувь урьдчилж өгсөн зэрэг зөрчил илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”... гэж заасныг, ХАХНХ-ын сайдын 2012 оны 10 дугаар сарын 29-ний А/51 тоот тушаалаар баталсан “Гэр оронгүй тэнэмлэл амьдралтай иргэнд үзүүлэх халамжийн үйлчилгээний журам”-ын 10.1.1, 10.1.2-д заасныг тус тус зөрчсөн байна.


“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Бүрдэл дутуу баримтаар олгосон 23,2 сая төгрөгийн гэрээний гүйцэтгэлийн холбогдох баримт материал, тайлан тооцоог хийж, биелэлтийг гарган 2013 оны 4 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сүхбаатар дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга Д.Сонгохбаяр, ерөнхий нягтлан бодогч Б.Алтангэрэл нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА:



ХҮЛЭЭН АВСАН:



070076